



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 06 дугаар сарын 21 өдөр Дугаар 60

Хэрлэн сум

LX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 60 дугаар хуралдаан 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 14.00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдаж

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даогаж холбогдох үүрэг даалгаврыг өгөв

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан Эмнэлэг /4 дүгээр тасаг/ нэмэлтээр дэлгэх талаар шаардагдах төсөв, мэдээлэл танилцуулах,

*Эрүүл мэндийн газар  
Бүсийн оношилгоо эмчилгээний төв*

2.Политехникийн коллежийн Оюутны дотуур байрыг дайчлах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулах,

*Эрүүл мэндийн газар*

3.Хөлөнбуйр болон сумдын хяналтын цэгт иргэдээс түргэвчилсэн тест авах эсэх талаар хэлэлцэх,

*Аймгийн Ерөнхий даргаар судлаач эмч*

4.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан сумдын Онцгой комисст албан чиглэл хүргүүлэх талаар хэлэлцэх,

*Аймгийн Ерөнхий даргаар судлаач эмч*

5.Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах бэлтгэл ажлын талаар мэдээлэл танилцуулах,

*Боловсрол, соёл урлагийн газар*

6.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан иргэдэд нөлөөллийн ажил зохион байгуулах талаар мэдээлэл танилцуулах,

*АЗДТГ-ын Олон нийттэй харилцах алба*

7.Аж ахуй нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

-Чойбалсан сумын Онцгой комисс

-Булган сумын Онцгой комисс

/ М.Бадамсүрэн

/ Хүр Г.Нармандах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

1.1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан батлагдсан тохиолдлыг эмчлэх эмнэлэг /4 дүгээр тасаг/ нэмэлтээр дэлгэхэд шаардагдах 12,084,500 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын дарга, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-д:

1.2.Хэрлэн сумын хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэх албан хаагчдын хоол хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин-д:

1.3.Батлагдсан тохиолдлыг эмчлэх эмнэлэг /4 дүгээр тасаг/-ийн хамгаалалтад үүрэг гүйцэтгэх Цагдаа, Онцгой байдлын байгууллагын албан хаагч нарын хоолны зардлыг шийдвэрлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.4.Политехникийн коллежийн дотуур байрны гадна хяналтын камер суурилуулах ажлыг зохион байгуулах, камер суурилуулахад шаардагдах зардал 300,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгох,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Бүсийн онсшилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

1.5.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдэж байгаа тул батлагдсан тохиолдлыг эмчлэх дараагийн эмнэлэг /5 дугаар тасаг/ дэлгэх бэлтгэл ажлыг хангах,


Хсёр.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

2.1.Политехникийн коллежийн Оюутны дотуур байрыг дайчлах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг нарт:

3.1.Хөлөнбуйр болон сумдын хяналтын цэгт иргэн бүрзэс шүлсээр түргэвчилсэн шинжилгээг авах ажлыг зохион байгуулах,

 /М.Бадамсүрэн  
 /Хур Г.Нармандах

Дөрөв.АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Э.Эрдэнэбилэг-д:

4.1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан аач хэрэгжүүлэх арга хэмжээний тухай албан бичгээр сумдын Онцгой комисст чиглэл хүргүүлэх,

Тав.Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн А.Нансалмаа-д:

5.1.Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах талаар Эрүүл мэндийн байгууллагатай зөвшилцөж сурагчдыг 2 давхарт байрлуулах, сурагчид байрлах байрны харуул хамгаалалтын хуваарь гаргах, сурагчдын хичээл давтах боломжийг бүрдүүлэх, сурагчдыг тээвэрлэх, буцаж суманд нь счиход 7 хоног гэрийн тусгаарлалтад оруулах, сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага хариуцаж ажиллах, Хэрлэн сумын сурагчдыг сургууль, гэр гэсэн маршрутаар зорчуулах, сумаас эцэг эхчүүдийг ирүүлэхгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ аач ажиллах тухай түр журам боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Зургаа.АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга,  
Онцгой комиссын гишүүн Э.Батболд-д:


6.1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан иргэдэд нөлөөллийн ажил зохион байгуулах санал боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Долоо.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
эрлөгч дарга, хурандаа Г.Нармандах-д:

7.1.Булган сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн албан бичгийн дагуу Булган сумын Онцгой комисстэй холбогдож шаардлагатай тооцсог судалж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын  
гишүүн Б.Ганганцэцэг-д:

7.2.Чойбалсан сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн албан бичгийн дагуу Хэрлэн сумын харьяатай хяналтын цэгийн гадна оршин суудаг малчин иргэдээс тандалтын шинжилгээг авах ажлыг зохион байгуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ  
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ  
ДАРГА, ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ